

## ШИНЭ НОМ

### Японы “Дипломатын Хөх ном 2019”

Японы Гадаад харилцааны яамнаас жил тутам эрхлэн гаргадаг “Дипломатын Хөх ном” нь тухайн жил дэх тус улсын дипломат үйл ажиллагааны талаарх хураангуй тайлан юм. Анхны дугаар нь 1957 оны 9 дүгээр сард “Японы Дипломат харилцааны өнөөгийн байдал” нэрээр гарсан ба 1971 оноос англи хэлээр давхар хэвлэгддэг болжээ. 1987 оноос буюу 31 дэх дугаараасаа эхлэн өнөөгийн нэрээрээ хэвлэгдэх болж, 2019 оныг хүртэл нийт 62 дугаар гарчээ. 2000 оноос Япон улсын Гадаад харилцааны яам цахим хуудсандаа /<https://www.mofa.go.jp/mofaj/gaiko/bluebook/> бүх дугаарыг япон, англи хэлээр нээлттэй байршуулах болсон нь цаг хугацаа, орон зайнд үл хашигдан Японы гадаад бодлого, дипломат харилцааны түүх өрнөлийг сонирхон судалдаг хэн бүхэнд чөлөөтэй танилцаж, ашиглах боломжийг хангажээ.

“Дипломатын Хөх ном”-д Япон улсыг тойрсон олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт хувиралт, түүнд баримталж буй тус улсын гадаад бодлогын чиглэл хандлага, дипломат харилцааны өрнөл, үйл ажиллагааг тайлбарласан байдаг. Энэхүү ном бичлэгийн хувьд товч тодорхой, энгийн бөгөөд олон нийт уншихад дөхөм байлгах зарчмыг баримталдаг байна. Мөн тухайн онд олон улсын талбарт идэвхитэй ажиллаж буй иргэд хувь хүний хувь нэмрийг тусгайлан мэдээ нийтлэл хэлбэрээр нийтэлдэг ажээ. Бүтэц агуулгын хувьд улс орнуудыг бүс нутгаар нь, улс бүрээр тусгайлан авч үзнэ. Чингэхдээ нийгмийн салбар бүрийн гадаад харилцааны төлөв байдал хийгээд олон улсын хамтын ажиллагааны оролцоо санаачлагууд хэмээн ангилан хуваадаг байна.

Тус ном Монгол Улсын талаар 1967 оны 11 дэх дугаартаа

анх дурдсан ба 1970 оныхоос бусад бүх дугаартаа Монгол-Японы харилцааны талаар он алгасалгүй нийтэлсээр иржээ. Тэдгээр нийтлэлүүд үйл явдлын бодит өрнөлийг товч, тодорхой өгүүлсэн байдаг тул хоёр улсын харилцааг сонирхон судлагч хэн бүхэн эрхбиш эх сурвалжийн хэмжээнд хэрэглэгдэхүүн болговол зохилтой. Жишээ болгох үүднээс 1967 оны дугаарт Монголын талаар анхлан дурдсан хэсгээс танилцуулья. “1966 оны 7 дугаар сарын 12-ны өдөр Монголын нийслэл Улаанбаатар хотод их хэмжээний аадар бороо орсны улмаас үерийн аюул хохирол учирсантай холбогдуулан Засгийн газраас тэр жилийн 8 дугаар сарын 16-ны өдөр Японы Улаан загалмайн нийгэмлэгээр дамжуулан 3000 долларын мөнгөн хандив өгөв”, “Монголд очиж япон цэргийн були эргэсэн нь. Өнөөг хүртэл зөвхөн цөөн тооны япон аялагч хувийн шугамаар очиж, Монголд байгаа япон цэргийн булиийг эргэж байсан ба одоо хүртэл нас барагсдын ар гэрээс очоогүй байсан бөгөөд 1966 оны 4 дүгээр сард Эх орондоо эргэж ирээгүй иргэдийн асуудал хариуцсан Зөвлөлийн дарга Фүжияма Айчирогийн БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбалд бичсэн захидлыг ЗХУ-д суух Элчин сайд Накагавагаас ЗХУ-д суугаа БНМАУ-ын Элчин сайдын гарт хүргэж, амь үрэгдсэн япон цэргийн ар гэрийнхэн Монголд очиж булиийг нь эргэх зөвшөөрөл хүссэн. Үүнд мөн оны 5 дугаар сард Ерөнхий сайд Ю.Цэдэнбалаас Фүжияма даргад илгээсэн хариу захидалд манай талын хүсэлтийг зөвшөөрсөн хариу ирүүлсэн тул Засгийн газар Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яам, Гадаад харилцааны яам болон Эх орондоо эргэж ирээгүй иргэдийн асуудал хариуцсан Зөвлөлийн хооронд зөвшилцөж, нас барагсдын ар гэрийн төлөөлөл 8 хүн болон Засгийн газрын дөрвөн албан хаагчаас бүрдсэн төлөөлөгчдийн баг мөн оны 8 дугаар сарын 2-ны өдөр Ханэдагаас Улаанбаатарт хүрсэн. Энэ багийг гурван зөвлөх (Парламентын 2 гишүүн, 1 нарийн бичиг) дагалдан явав. Улаанбаатар болон Сүхбаатар хотын нутагт орших япон цэргийн оршуулгын газрыг эргэсэн бөгөөд төлөөлөгчид тэр жилийн 8 дугаар сарын 30-нд Ханэда руу буцав”<sup>1</sup> хэмээн тухайн үеийн хоёр улсын

<sup>1</sup> 『わが外交の近況(第11号)』外務省 昭和42年12月、「三 わが国と各国との間の諸問題、アジア地域」<https://www.mofa.go.jp/mofaj/gaiko/bluebook/1967/>

харилцааны талаар тоймлон өгүүлсэн нь сонирхол татаж байна.

Шинэхэн хэвлэгдсэн 2019 оны Японы “Дипломатын Хөх ном” дөрвөн бүлэгтэй бөгөөд тогтсон зарчмын дагуу 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд өрнөсөн олон улсын байдал болон Япон улсын явуулж буй дипломат үйл ажиллагааны талаарх тойм мэдээлэл хийгээд 2019 оны 3 дугаар сар хүртэлх зарим чухал үйл явдлыг багтаажээ.

I бүлэгт Япон улсыг хүрээлэн буй олон улсын нөхцөл байдал ба Япон улсын дипломат харилцааны өрнөл; II бүлэгт дэлхийн хэмжээнд явуулж буй дипломат бодлого; III бүлэгт үндэсний эрх ашиг ба даян дэлхийн ашиг сонирхолыг дэмжих гадаад бодлого; IV бүлэгт хилийн чанад дахь япон иргэдтэй болон гадаад ертөнцтэй харилцаа холбоогоо гүнзгийрүүлэн хөгжүүлж буй Японы аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн Гадаад харилцааны яамны дэмжлэг тусламжийн талаар тус тус өгүүлжээ. Түүнчлэн уншигчдыг дипломат ажилтай илүү ойртуулахын тулд энэ оны дугаартаа шинээр цөөнгүй гэрэл зурагтай танилцуулгыг тусгайлан нэмж оруулжээ. Номын төгсгөлд олон улсын байгууллагыг сонирхон буй хүмүүст зориулан гадаад харилцааны холбогдолтой олон төрлийн лавлагаа мэдээ материалыг хавсаргажээ.

Уг дугаарт Монгол-Японы харилцааны тухайн жилийн өрнөлийг хэрхэн тэмдэглэсний агуулгийг дор тоймлон өгүүлвэл,

Монгол Улс бол Японтой нийтлэг үнэт зүйлс бүхий бүс нутгийн чухал түнш бөгөөд цаашид ч “стратегийн түншлэл”-ийн найрамдалт харилцаагаа харилцан ашигтайгаар улам бэхжүүлэн бататгасаар байх болно.

2018 онд хоёр орны Засгийн газар хооронд, 2 дугаар сард Гадаад хэргийн сайд нарын уулзалт (Токио хотноо), 4 дүгээр сард гурав дахь удаагийн Япон-Монголын стратегийн түншлэлийн хэлэлцүүлэг (Токио хотноо), 9 дүгээр сард Ерөнхий сайд Шинзо Абэ Ерөнхий сайд У.Хүрэлсүх нарын дээд хэмжээний уулзалт (ОХУ,

Владивосток), 12 дугаар сард мөн Ерөнхий сайд Шинзо Абэ Ерөнхий сайд У.Хүрэлсүх нарын дээд хэмжээний уулзалт (Токио хотноо) зэрэг өндөр түвшний харилцаа идэвхтэй өрнөв.

Мөн олон талт яриа хэлэлцээний санаачлагын хүрээнд 4 дүгээр сард гурав дахь удаагийн Япон-Америк-Монгол гурван улсын зөвлөлдөх уулзалт (Токио хотноо) зохион байгуулснаас гадна 8 дугаар сард Япон улсын Ерөнхий сайдын тусгай зөвлөх Кэнтаро Соноүра Монгол Улсад айлчилж, Батлан хамгаалах салбарын “Чадавхийг сайжруулах хөтөлбөр”-ийн хаалтын ёслолд оролцлоо.

Парламентийн түвшинд, 6 дугаар сард УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Японы парламентийн бүлгийн дэд дарга Л.Энх-Амгалан Японд айлчилсны дараа 10 дугаар сард Япон улсын Зөвлөхүүдийн танхимын дэд дарга Акира Гүнжи Монгол Улсад айлчлав. Өнгөрсөн жилийн Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд, Японы Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Тадамори Оошима нарын харилцан айлчлалыг үргэлжлүүлсэн парламентийн дэд дарга нарын харилцан айлчлал хоёр орны хууль тогтоох байгууллага хоорондын харилцааг улам бэхжүүлэв.

Мөн 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн айлчлалын үеэр хийсэн Япон-Монголын дээд хэмжээний уулзалтын дараа хоёр тал хамтарсан мэдэгдэл гаргаж, өмнөх оны 3 дугаар сард Гадаад хэргийн сайд нарын гарын үсэг зурсан “Япон, Монголын Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)”-ийн явц байдлыг бататгасан баримт бичиг гаргасан. Цаашид ч үргэлжүүлэн тус төлөвлөгөөний дагуу хоёр орны харилцааг тасралтгүй бэхжүүлж, хоёр орны “стратегийн түншлэлийн харилцаа”-г хөгжүүлэхийн төлөө хичээн ажиллах болно хэмээн дурджээ.

*Мэдээ бэлтгэсэн:*

*Эрдэм шинжилгээний дэд ажилтан, магистр  
Амарбатын Сосорбурам*